

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН НОГДУУЛАЛТ,
ТӨЛӨЛТИЙН БАЙДАЛ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦЭЖ
БУЙ ЭСЭХ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН
АУДИТЫН КОД: БНА-2019/35/-НА

Баянхонгор хот 2019 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга**
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цэням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyama@audit.gov.mn
Аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Н.Бүнчинсүрэн
Утас: 99049866 цахим хуудас: nbunchin0719@gmail.com
Аудитор Г.Ганчимэг
Утас: 88268424 цахим хуудас: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
СГЗ	Сав газрын захиргаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Тайланг хянасан:
Баянхонгор аймаг
дахь Төрийн
аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Б.Мөнхбат

Хэлтсийн дарга
бөгөөд аудитын
менежер

А.Цээням
Тайланг бэлтгэсэн:
Ахлах аудитор
Б.Азбаяр

Аудитор
Н.Бүнчинсүрэн
Г.Ганчимэг

2019 оны 10 дүгээр
сарын 16-ны өдөр

Уг тайланг УАГ-ын
Цахим хуудаснаас
үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442424 дугаарын
утас, 70442584
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-
64000
Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд	4
Үндсэн мэдээлэл	5
НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН	7
БҮЛЭГ 1	7
УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨЖ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУУЛИЙН ДАГУУ ЗАРДЛЫГ БАТАЛСАН ЭСЭХ	7
1.1. УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ӨМНӨХ ЖИЛҮҮДИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН НЬ БОДИТ БУС БАЙНА	7
1.2. УС АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ УС АШИГЛАХ ДҮГНЭЛТ, УС АШИГЛАХ ГЭРЭЭГ БҮРЭН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА	8
1.3. УС РАШААН АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ, МЭДЭЭЛЭЛ НЭЭЛТТЭЙ БУС БАЙГААГААС ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	12
БҮЛЭГ 2	14
2.1. Бөөнцагаан Орог нуурын сав газар нь УС АШИГЛАХ ДҮГНЭЛТИЙГ АЛДААТАЙ ГАРГАЖ БАЙНА	14
2.2. ЗАРИМ УС АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГА НЬ УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТАЙЛАНГ ТАТВАРЫН ЦАХИМ СИСТЕМД ХУУЛИЙН ДАГУУ БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙХАД АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	17
2.3. УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ЗАРИМ АЖ АХУЙН НЭГЖҮҮД ТАЙЛАНТ ХУГАЦААНДАА БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	18
АУДИТЫН ДҮГНЭЛТ	25
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	26

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/03 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд аудит хийж, аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ, холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:

1. Ус, рашаан ашиглахтай холбогдсон харилцаа хуулийн дагуу хэрэгжиж байна уу?

2. Ус, рашаан ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үйл явц хуульд нийцэж байна уу?

Аудитыг Ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлт, ногдуулалт, төлөлтийн байдлыг аймгийн Засаг дарга, бусад холбогдох байгууллагуудын 2016-2018 он, 2019 оны эхний хагас жилийн мэдээ, тайлан, ус ашиглагчидтай байгуулсан гэрээ, Төрийн сангийн дансны хуулга, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоолууд
- Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоолоор баталсан “ Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журам
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням аудитын үе шат бүрд хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Н.Бүнчинсүрэн, Г.Ганчимэг нар 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 09 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аймгийн ИТХ, Засаг дарга болон бусад холбогдох байгууллагуудад тайланг хүргүүлэв.

Үндсэн мэдээлэл

Ус, рашаан ашиглалтын төлбөрийн орлогын төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар батлуулж ирсэн бөгөөд 2016 оноос 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1335,8 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, 1220,1 сая төгрөгийг төсөвт оруулсан байна.

Хүснэгт:1 Ус, рашаан ашиглалтын төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл:

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
2016	410,000.0	430,131.6	104.9
2017	405,898.8	438,858.8	108.1
2018	400,000.0	257,938.2	64.5
2019 /хагас жил/	120,000.0	93,191.6	77.7
Дүн	1,335,898.8	1,220,120.2	91.3

Усны тухай хуулийн 28.4¹-т заасны дагуу ус ашиглагч аж ахуй нэгж байгууллагад аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа ус ашиглах зөвшөөрөл олгож дүгнэлт гарган, гэрээ байгуулан ажиллаж, 2016-2019 оны эхний хагас жилийн байдлаар 137 дүгнэлт гаргаж 7705632 м3 ус ашиглах эрх олгосон байна.

¹ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана

Үйлдвэрлэл, үйлчилгээ, хайгуулын зориулалтаар олгосон усны хэмжээг
хүснэгтээр харуулбал /м3-ээр/

д/д	Зориулалт	Онууд				Нийт дүн
		2016	2017	2018	2019	
1	Үйлдвэрлэлийн зориулалтаар	790930.3	1030798.8	1424962	1174668	4421358.6
2	Хайгуул, өрөмдлөг хийх	6013.66	8888.34	14192.24	7277.38	36371.62
3	Тоосго үйлдвэрлэх			367.5		367.5
4	Нүүрс олборлох	1194.6	4,392.20	1320.5	1170	8077.3
5	Авто угаалга		350.4	316.8		667.2
6	Хүдэр баяжуулах	12335.86	13,037.0	8134.16		33506.98
7	Төвлөрсөн усан хангамж	678686	740603	750520	750112	2919921
8	Эрчим хүчний үйлдвэрлэл/ уурын зуух, сум/			2667.26		2667.26
9	Эрчим хүчний үйлдвэрлэл/ уурын зуух, аймаг/	90361.44	0	0	0	90361.44
10	Рашаа ашиглагч	44280	44448	51028.8	51353.8	191110.6
11	Зочид буудал, ресторан				1062.6	1062.6
12	Жуулчны бааз				159.9	159.9
	Жилийн дүн	1623801.86	1842517.7	2253509.3	1985803	7705632

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

Ус, рашаан ашиглахтай холбогдсон харилцаа хуулийн дагуу хэрэгжиж байна уу?


БҮЛЭГ 1.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим томоохон ус ашиглагч байгууллагууд дүгнэлт гаргуулаагүй, гэрээ хийгээгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн нь бодит бус байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.

Аудитаар ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг ус ашиглах дүгнэлттэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. /График № 01/



Төлөвлөлтийг хэрхэн тооцож талаар холбогдох мэргэжилтнээс тодруулахад:

“Ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг төвлөх үед хэдэн аж ахуйн нэгж ус ашиглах нь тодорхойгүй, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас ирүүлсэн ус ашиглагчийн судалгаа нь төлөвлөж буй он бус тухайн тайлант онд ус ашиглаж байгаа ус ашиглагчийн судалгааг ирүүлдэг. Иймд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд тулгуурлан дунджаар төлөвлөж байгаа” гэсэн тайлбарыг өгөв.

2020 оны төсвийн төсөл боловсруулахад Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас ус ашиглагч байгууллагуудын төлбөрийн мэдээ тайлан гаргуулж авсан боловч мэдээ судалгаа гаргахдаа орон алдсан, оронгийн нарийвчлал, хэмжих нэгжийг буруу илэрхийлсэн, ус ашиглах дүгнэлт гаргуулсан зарим аж ахуйн нэгж байгууллагыг орхигдуулсан байгаа нь уг тайлан мэдээгээр орлого төлөвлөх бололцоогүй тул цаашид хариуцсан албан тушаалтнууд мэдээг үнэн зөв гаргаж, ажлын хариуцлагатай хандах шаардлагатай байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын ногдуулалтад хяналт тавиагүйгээс ус ашиглагч нь төлбөрт төлсөн дүнгээр ногдуулалтыг хийж, өр, авлагыг бүрэн тусгаагүй, зарим ус ашиглагч нь гэрээ байгуулаагүй, тоолуургүй аж ахуйн нэгжүүд дүгнэлтээр гарсан усны төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй, ус ашиглагч ус, рашаан ашиглагчийн төлбөрийн тайланг гаргаагүй байхад орлогын гүйцэтгэлээр төлөвлөлтийг бодитой бус хийж байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдаж байна.

Иймд ус, рашаан ашигласны төлбөрийн орлоготой холбоотой зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн тайлан мэдээг гаргасан дүгнэлттэй харьцуулан үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлан үзэж, төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж буй эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан хуульд заасны дагуу төсвийг аймгийн БОАЖГ-ын төсөвт оруулан жил бүр баталж байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1—²д заасан заалттай нийцэж байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого болон Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний талаарх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1

/сая.төг/

№	Он	Орлогын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Байгаль хамгаалах арга хэмжээнд батлагдсан төсөв	Зардлын орлогод эзлэх хувь
1	2016	410.0	430.1	-20.1	104.9	143.5	35
2	2017	405.8	438.8	32.9	108.1	142.0	34.9
3	2018	400.0	257.9	142.0	64.4	140.0	35
4	2019	250.0	235.2	14.8	94.0	87.5	35



1.2. 2016-2019 оны байдлаар давхардсан тоогоор 199 ус ашиглагч ус ашиглах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулахаас 62 ус ашиглагч дүгнэлт гаргуулаагүй, 78 ус ашиглагч ус ашиглах гэрээ байгуулаагүй байгаа Усны тухай хуулийн 18.1.4³, 28.4⁴, дахь заалтуудыг зөрчсөн байна.

² Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно. 5-р хэсэгт. “Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 35 хувь

³ “ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх”

⁴ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

Усны тухай хуулийн дагуу хоногийн хэрэгцээ 50 м³-ээс доош ус ашиглагчийн ус ашиглах дүгнэлтийг аймгийн БОАЖГ гаргаж, ус ашиглах гэрээг сумдын Засаг дарга, хоногийн хэрэгцээ нь 50м³-100 м³ ус ашиглах дүгнэлтийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа гаргаж, гэрээг БОАЖГ, хоногийн хэрэгцээ нь 100м³ –ээс дээш ус ашиглах дүгнэлтийг “Монгол-Ус” ТӨАТҮГ гаргаж, гэрээг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа байгуулж ажиллаж байна.



➤ Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

“Монгол-Ус” ТӨАТҮГ-аас уул уурхайн ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгж байгууллагуудад ус ашиглах дүгнэлт гаргаж Бөөнцагаан орог нуурын сав газар гэрээг байгуулсан байна. Тухайлбал:

- 2016 онд 9 ус ашиглагчид ус ашиглах дүгнэлт гаргаснаас “Монгол Болгар Гео” ХХК-аас бусад ус ашиглагч нартай гэрээ байгуулсан эсэх нь тодорхойгүй, гэрээ нь байхгүй,

- 2017 онд 10 ус ашиглагчид ус ашиглах дүгнэлт гаргаснаас “Жамп алт” ХХК, “Нинж мөрөн” ХХК-тай гэрээ байгуулаагүй,
- 2018 онд 12 ус ашиглагчид ус ашиглах дүгнэлт гаргаснаас “Жамп” ХХК, “Эрдэнэ-цагаач” ХХК-тай гэрээ байгуулаагүй байна.

➤ **Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй**

Байгаль орчин аялал жуулчлалын газраас усны тухай хуулийн дагуу 2016-2019 онуудад хайгуул, өрөмдлөг, хүдэр баяжуулах үйлдвэр, уурын зуухны үйл ажиллагаа эрхэлдэг 83 аж ахуй нэгж байгууллагад ус ашиглах дүгнэлт гаргажээ.

Дүгнэлт төрлөөр авч үзвэл



БОАЖГ нь дээрх дүгнэлт гаргуулсан ашиглагчийн ус ашиглах төлбөрийн ногдуулалтыг хийж татварын хэлтэст хүргүүлээгүй, сумын Засаг дарга, байгаль хамгаалагч нар ус ашиглах гэрээ байгуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, ус ашиглах дүгнэлт гаргуулсан хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын өмнөх жилийн ажлын гүйцэтгэл, усны тайланг хүлээн авч хэрэгжилтийг тооцоогүй байхад дахин хайгуулын дүгнэлтийг гаргаж өгч байна.

➤ **Төвлөрсөн усан хангамж /“Чандмань-Баянхонгор”ХК/**

Аймгийн БОАЖГ нь Байгаль орны яамаар ус ашиглах дүгнэлт гаргуулж Бөөнцагаан Орог нуурын сав газраас зөвшөөрөл авсан “Чандмань-Баянхонгор” ХК-тай 2016-2019 онд ус ашиглах гэрээг байгуулж ажиллаагүй байна.

Энэ талаар аймгийн БОАЖГ-аас тодруулга авахад “Чандмань-Баянхонгор” ХК нь ус ашиглах дүгнэлт гаргуулдаг боловч ус ашиглалтын тайлан мэдээг дутуу явуулдаг, ус ашиглах дүгнэлтэд ногдуулалт бага гардаг тул тухайн онуудад гэрээ байгуулаагүй” гэсэн тайлбарыг албан тоотойр ирүүлэв. Гэвч тайлан дутуу ирүүлэх, дүгнэлтээр гарсан ногдуулалт бага гэсэн шалтгаанаар гэрээ байгуулахгүй байх хуулийн үндэслэл байхгүй тул гэрээг хуульд заасны дагуу байгуулж ажиллах албан шаардлагыг БОАЖГ-т хүргүүлэв.

Мөн Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь Усны тухай хуулийн 29.1⁵-т заасны дагуу ус ашиглагч байгууллагуудтай ус

⁵ Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, ... гэрээ байгуулна.

ашиглах гэрээг байгуулж ажиллаагүй байна. Цаашид ус ашиглах гэрээг ус ашиглагч нартай хуулийн дагуу байгуулах зөвлөмжийг “Чандмань Баянхонгор” ХК –д хүргүүлээ.

➤ **Бусад ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага**

Сумдад үйл ажиллагаа явуулж буй 16 уурын зуухнаас 2018 онд 6 уурын зуух ус ашиглах дүгнэлт гаргуулсан боловч сумын Засаг даргатай ус ашиглалтын гэрээ байгуулаагүй усны төлбөрийн ногдуулалт бүрэн хийгдээгүй байна. Мөн 2019 онд нэг ч сумын уурын зуух дүгнэлт гаргуулж гэрээ байгуулаагүй байгаа нь Усны тухай 18.1.4⁶, 28.4⁷, дахь заалтуудыг зөрчсөн байна.

Мөн аймгийн төвийн төвлөрсөн шугам сүлжээнд хамрагдаагүй ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагууд тухайлбал: зуурмаг боловсруулах үйлдвэр, нийтийн халуун ус, авто угаалгын газруудад дүгнэлт гаргаж, гэрээ байгуулж усны төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Иймд сумдын уурын зуухны усны бодит хэрэглээ болон гүйцэтгэлийг бүрэн тооцож, дүгнэлт гаргаж, хуулийн дагуу ногдуулалтыг хийж, хэрэгжилтийг тооцож ажиллахыг БОАЖГ-т зөвлөмжийг хүргүүлэв.

➤ **Рашаан сувилал**

Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй рашаан сувиллууд дүгнэлтийг гаргаагүй, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд нь Усны тухай хуулийн 13.1.2⁸, 28.4⁹, дахь заалтыг хэрэгжүүлээгүй ажиллаагүй байна. Тухайлбал:

➤ “Шаргалжуут рашаан сувилал” ХХК нь 2016-2019 онуудад ус ашиглах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулсан боловч гэрээ дүгнэж, хяналт тавиагүй.

➤ Өлзийт сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Баян-Ундарга Зэндмэнь” ХХК нь 2016-2019 онуудад ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авсан боловч гэрээ байгуулаагүй

➤ Баянхонгор сумын 8-р багт орших Шаргалжуут рашаан түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа “Амар амгалан Шаргалжуут” ХХК нь дүгнэлт гаргуулаагүй байхад Баянхонгор сумын Засаг дарга гэрээ байгуулсан.

➤ Баянхонгор сумын 8-р багт орших “Ганууд” ХХК нь дүгнэлт гаргуулж гэрээ байгуулаагүй.

⁶ “ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх”

⁷ “... 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”

⁸ Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих

⁹ “... 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”

Иймд дээрх зөрчлийг арилгаж дүгнэлт гаргаж, гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг Бөөнцагаан-Орог нуурын сав газар, аймгийн БОАЖГ, холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Харьяа нутаг дэвсгэрт 2016-2019 онд үйл ажиллагаа дүгнэлт гаргуулж, үйл ажиллагаа явуулж байхад гэрээ байгуулж ажиллаагүй Өлзийт сумын Засаг дарга Д.Цэдэнсодном, дүгнэлт гаргуулаагүй байхад “Амар амгалан Шаргалжуут” ХХК-тай хууль зөрчиж гэрээ байгуулсан Баянхонгор сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитад хамрагдсан 2016-2019 онуудад ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, гэрээ байгуулаагүй ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг гарган Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн МХГ-т хүргүүлэв.

1.3. Ус рашаан ашиглагч байгууллагуудад тавих хяналт сул, мэдээлэл нээлттэй бус байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Усны тухай хуулийн 17.1.10¹⁰ -д сав газрын захиргааны бүрэн эрхийг тодорхойлсон ба дээрх хуулийн дагуу Бөөнцагаан Орон нуурын сав газрын захиргаанаас хяналт шалгалт хийсэн материал шаардсан боловч архивласан баримт материалд хяналт хийсэн тайлан материал байхгүй гэсэн тайлбар өгөв.

Аудитаар Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргааны албан томилолтын зардлыг түүвэрлэн хяналтаар ажилласан эсэхийг судалж үзэхэд 2016 онд 5 удаа, 2017 онд 3 удаа, 2018 онд 3 удаагийн ус ашиглалттай холбоотой хяналт шалгалт хийсэн томилолтоор ажилласан тайланд тайлагнасан байна. Тухайлбал:

2016 онд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2016 оны 06 сарын 08,09-ны өдрүүдэд “Хөх бүрдний эх” ХХК, “Их богд” ХХК тоосгоны үйлдвэрүүд, хөшөөт, Бумбатын услалтын системүүд, “Өвөр өнц”-д нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж буй “Бурам арвижих” ХХК-ний 1,2-р шугам, “Баян-Ундарга зэндмэнэ” рашаан сувилал зэрэг аж ахуйн нэгж, компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт, ажлын зураг авалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан”

2017 онд Баянцагаан, Жинст, Баян-Өндөр, Баянговь сумдын хүн амын унд ахуйн ус болон шинээр ашиглалтад орсон уурын зуухнуудад ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар “Бэст хонгор” ХХК нь Баянцагаан, Жинст, Баян-Өндөр, Баянговь сумдад 4 уурыг ашиглалтад оруулсан боловч ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулаагүй зөрчил илэрсэн”

¹⁰ сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах

2018 онд “Аймгийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны А/585 дугаар захирамжийн дагуу аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, зоогийн газар, амралт рашаан сувилал, жуулчны баазын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтад аялал жуулчлал, амралт рашаан сувиллын үйл ажиллагаа явуулж буй 14 аж ахуй нэгж хамрагдсан”

Дээрх тайлангаас харахад ямар төрлийн зөрчил илрээд хэрхэн шийдвэрлэсэн эсэх нь тодорхойгүй, үр дүнг тооцоогүй, асуудал шийдвэрлэсэн шийдэл байхгүйгээс харахад хяналт үр дүнгүй хийгдсэн гэж үзэхээр байна.

Аудитаар ус ашиглагч байгууллагуудад газар дээр нь очиж үзэхэд тоолуур суурилагдсан усны эх үүсвэрт, ажил эхлэх дуусах үед нь тоолуурын үзлэг шалгалт хийж тоолуурын заалтыг баталгаажуулж акт үйлддэггүй зөрчил илрэв.

Энэ талаар “Бөөнцагаан Орон нуурын сав газрын захиргаа”-ны удирдлагаас тодруулахад “Манай байгууллагын төсөвт шатахууны зардал сард 259,0 мянган төгрөг л байдаг, энэ нь ус ашиглагч рашаан сувилал, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй уурхай, сумдын төвлөрсөн уурын зуух гэх мэт олон газраар тойрч явах бололцоогүй байдаг” гэсэн тайлбар өгөв.

Мөн аймгийн Татварын хэлтэс нь ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдалд хэрхэн хяналт хийсэн талаар тодруулахад “Манай байгууллага нь эрсдэлд суурилан татварын хяналт шалгалтыг Ерөнхий газраас батлагдсан төлөвлөгөөний дагуу хийдэг бөгөөд 2016-2019 онд ус рашааны төлбөрийн орлогын байдалд сэдэвчилсэн хяналт шалгалт хийгдээгүй” гэсэн тайлбар өгөв.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ус, рашаан ашиглагч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийсэн талаар материал ирүүлэхийг албан бичгээр хүсэлт хүргүүлсэн боловч хяналт шалгалтын материал ирүүлээгүй болно. Аудитын явцад хариуцсан байцаагчтай холбогдоход “хяналт шалгалтаар явсан материалыг өгөх боломжгүй” гэсэн бөгөөд Аудитын явцад МХГ-ын холбогдох байцаагчаас материал гаргуулахад “Шаргалжуут рашаан сувилал” ХХК-аас өөр ус ашиглагчид хяналт хийгдээгүй байна.

“Шаргалжуут рашаан сувилал” ХХК-ийн үйл ажиллагаанд 2019.05.08-нд хийсэн хяналт шалгалтын удирдамжтай танилцахад өмнө **хийсэн шалгалтын талаарх мэдээлэл хэсэгт** ус хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламж шугам сүлжээний ашиглалтыг шалгах 5.37.2 кодтой хяналтын хуудсаар 2016, 2017, 2018 онуудад албан шаардлага өгсөн боловч биелүүлээгүй гэж тусгасан байна.

Хяналт сул байгаагаас “Амар-Амгалан Шаргалжуут” ХХК нь Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, нам даралтын зуух барьсан, бохир зайлуулах цэг тогтоолгоогүй, бохир зайлуулах цооног байгуулсан зэрэг зөрчлүүд илрэв. Иймд зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлэв.

Дээрх нөхцөл байдлаас харахад ус ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын хяналт сул, мэдээлэл нээлттэй бус байгаагаас ус, рашаан ашиглагчтай гэрээ хийгээгүй, усны тайланг бүрэн гаргаагүй, зөвшөөрөлгүй ус ашигласан, төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлүүд илэрч байна.

Иймд эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан, мэдээллийн ил тод байдлыг хангуулж, хяналтын мөрөөр илэрсэн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс хүргүүлэв.

Ус, рашаан ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үйл явц хуульд нийцэж байна уу?

БҮЛЭГ 2.

Эрх бүхий байгууллагын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалж ус, рашаан ашигласны төлбөрийн орлого бүрэн төвлөрөөгүй, төлбөрийн тайлан бүрэн, үнэн зөв гараагүй байна.

2.1. Бөөнцагаан Орог нуурын сав газар нь ус ашиглах дүгнэлтийг алдаатай гаргаж байна.

“Монгол ус” ТӨҮГ, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрууд ус ашиглах дүгнэлт гаргахдаа захиалагч байгууллагаас ирүүлсэн материалд үндэслэн дүгнэлт гаргаж, Засгийн газрын 302¹¹, 327¹², 326¹³ тоот тогтоолуудаар баталсан аргачлалын дагуу усны төлбөрийг тооцож байна.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 390 дүгээр тогтоолд “улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ, сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах дүгнэлтийг Монгол Ус ТӨҮГ-аар гүйцэтгүүлэх”-ээр заасан байхад “Шаргалжуут рашаан сувилал”-ын ус рашаан ашиглах

¹¹ “усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ”

¹² “ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”

¹³ “усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тооцох аргачлал”

дүгнэлтийг 2016, 2018, 2019 онд Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа хууль зөрчин ус ашиглах дүгнэлтийг гаргасан нь Усны тухай хуулийн 28.4¹⁴ заасан заалтыг зөрчжээ.

Аймгийн БОАЖГ нь 2016 онд уул уурхай ашиглалтын А лицензтэй “Спейшл майнз” ХХК, “Андын тэмүүлэл” ХХК-д дүгнэлт гаргаж өгсөн нь Усны тухай хуулийн 28.4¹⁵ дахь заалтыг зөрчсөн байгаа ба тухайн үед ажиллаж байсан дарга, холбогдох мэргэжилтэн нь ажлаас чөлөөлөгдсөн учраас хариуцлага тооцох боломжгүй байна.

Харин “Спейшл майнз” ХХК нь зөрчлийг арилгаж 2017 онд дүгнэлтийг нөхөн гаргуулсан байна.

Аудитаар Бөөнцагаан Орог нуурын сав газар, БОАЖГ-н Усны тухай хуулийн 28.4¹⁶ дахь заалтыг зөрчиж ус ашиглах дүгнэлт гаргасан, усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, итгэлцүүр, төлбөрийн хувь хэмжээг буруу ногдуулсан, ашиглах усны хэмжээг тооцохдоо метр куб, тооны нарийвчлал алдаж тооцсон зэрэг нийтлэг зөрчил илэрлээ. Тухайлбал:

2018 онд “Мөнхийн номхон далай” ХХК-ны хайгуулын дүгнэлт гаргахдаа орон таслалыг буруу тооцсоноос 1751,0 мянган төгрөг зөрүүтэй тооцсон тул зөрүүтэй тооцсон төлбөрийг нөхөн тооцож төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мөн “Эрдэнэ Монгол” ХХК-ны дүгнэлтийг буруу гаргасан байсан боловч гэрээг хийхдээ ногдуулалтыг зөв тооцож усны төлбөр төлүүлжээ.

“Шаргалжуут рашаан сувилал”-ын ус ашиглах дүгнэлтийг гаргахдаа байгалийн нөөц ашигласны нөөцийн тухай хууль зөрчиж халаалтын зардлыг халуун рашааны ундаргаар тооцсон, эмчлүүлэгч амрагчдын тоог захиалагч байгууллагаас ирүүлсэн усны гүйцэтгэлийн тайланд үндэслэн тооцоо судалгаа хийж гүйцэтгэлийг тооцож гаргаагүйгээс 35,1 сая төгрөгийг усны төлбөр дутуу ногдуулсныг нөхөн тооцож аудитаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

¹⁴ “Хоногт 100 шоометрээс их ... ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана”

¹⁵ “...50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа...”

¹⁶ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

Шаргалжуут рашаан сувилалын халаалтын зардал					Сая.төг			
Байрны нэр	Халаах сар		Эзэлхүүн	Тариф	Халаалтын төлбөр аудитаар			
	Ашиглагч	Аудитаар			2016	2017	2018	2019
Үүнээс:Төв байр 1 давхар	6	6	2065	617	7.6	7.6	7.6	7.6
Төв байр 2 давхар	2	4	2065	617	5.1	5.1	5.1	5.1
Төв байр 3 давхар	2	4	2065	617	5.1	5.1	5.1	5.1
50 орт	2	3	2030	617	3.8	3.8	3.8	3.8
Эмнэлэг	3	4	2070	617	5.1	5.1	5.1	5.1
Саун спа	2	2	205	617	0.3	0.3	0.3	0.3
Гэгээнтэн 1 давхар	2	2	1610	617	-	-	-	2.0
Гэгээнтэн 2 давхар	2	2	1400	617	-	-	-	1.7
Дүн			13510	617	27.0	27.0	27.0	30.7
Ус ашиглах дүгнэлтээр					20.0	20.0	18.2	18.2
Зөрүү					7.0	7.0	8.7	12.4
Нийт зөрүү					35.1			

Цаашид Усны дүгнэлт гаргахдаа аргачлалын дагуу үнэн зөв тооцож, мэргэжлийн түвшинд ус ашиглах дүгнэлт гаргаж ажиллах зөвлөмжийг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд хүргүүлэв.

Мөн БОАЖГ сумдын уурын зуухнуудад 2016, 2017 онд ус ашиглах дүгнэлт гаргаагүй бөгөөд 2018 онд 7 сумын уурын зууханд дүгнэлт гаргахдаа үнийн дүнг тооцож гаргаагүй, хэт бага ус ашиглахаар дүгнэлт гаргажээ. Энэ талаар БОАЖГ-ын мэргэжилтнээс тодруулга авахад “*тухайн зуухны систем дүүргэлт болон нөхөн сэлбэлтийг ус ашиглагчид өөрөө тооцож ирүүлдэг, ирүүлсэн материалд үндэслэж дүгнэлт гаргаж байгаа*” гэсэн тайлбар өгсөн болно.

Үйл ажиллагаа явуулж буй сумдын уурын зуухнуудад дүгнэлт гаргаагүй, “Чандмань Баянхонгор” ХК-ийн дүгнэлт гарсан байхад гэрээ байгуулж ажиллаагүй, Усны тухай хуулийн 29.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн МХГ-т хүргүүлэв.

Цаашид сумдын төвлөрсөн уурын зуухны дүгнэлтийг бүрэн гаргаж, тоолуур суурилуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, ажиллах зөвлөмжийг аймгийн БОАЖГ-т хүргүүлэв.

Бөөнцагаан Орог нуурын сав газраас ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөрт дүгнэлт гаргаагүй байгаа нь Усны тухай хуулийн 24.2¹⁷-т дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

¹⁷ 24.2.Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.


Энэ нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.2¹⁸-д заасны дагуу Засгийн газраас ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг батлагдаагүйтэй холбоотой .

2.2. Зарим ус ашиглагч байгууллага нь Ус, рашаан ашигласны төлбөрийн тайланг татварын цахим системд хуулийн дагуу бүрэн мэдээлээгүй байхад аймгийн Татварын хэлтэс холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд 2016-2019 онд ус ашиглах дүгнэлт гаруулсан болон усны төлбөр төлсөн 127 аж ахуй нэгж байгууллагаас 81 ус ашиглагч 2016-2018 онд тайлан гаргасан боловч тайланг стандарт маягтын дагуу тайлагнаагүй, үйл ажиллагаа явуулсан боловч “Х” тайлан илгээсэн, ногдуулалтыг төлсөн усны төлбөрийн дүнгээр ногдуулалт хийж тайлан гаргасан өглөг авлагыг тусгаагүй зэрэг зөрчилтэй тайлан илгээсэн байхад татварын байцаагч шалгаагүй тайланг хүлээж авсан зэрэг нийтлэг зөрчил илэрлээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2¹⁹-т заасны дагуу ус ашиглалтын тайланг харьяалагдах татварын албанд ирүүлж жилийн тооцоогоо хийнэ гэж заасан үүргээ биелүүлээгүй, татварын тайлан гаргалт хангалтгүй байна.

Иймд ус ашиглагч аж ахуй нэгж байгууллагын тайланг хүлээж авахдаа ус ашиглах, дүгнэлт болон ус ашиглалтын тайлан, гэрээ дүгнэсэн холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн усны ногдуулалтыг бүрэн шивж тайлагнасан эсэхийг шалгаж тайланг хүлээн авах, хуулийн дагуу усны тайлангаа ирүүлээгүй аж ахуй нэгж байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.



¹⁸ Төлбөрийн хэмжээг усны сав газар тус бүрээр усны экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн энэ хуулийн 7.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.

¹⁹ 23.2¹⁹. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг д араа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

2.3. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг зарим аж ахуйн нэгжүүд тайлант хугацаандаа бүрэн төвлөрүүлээгүй байна.

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ус ашиглагч

Аймгийн хэмжээнд 2016-2019 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 20 уул уурхайн компани үйл ажиллагаа явуулсан ба тэдгээрийн дүгнэлтийг хуулийн дагуу “Монгол-Ус”ТӨАТҮГ гаргаж, Бөөнцагаан Орог нуурын сав газар ус ашиглах гэрээг байгуулан ажилласан байна.

Усны тухай хуулийн 30.1.4²⁰ -т заасны дагуу тоолуур суурилуулсан ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагын ус, рашаан ашигласны төлбөр ус ашиглах дүгнэлтээр 1879.5 сая төгрөг тооцогдож байгаа боловч тоолуур суурилуулж усны төлбөрийг тоолуурын заалтаар төлснөөр 357.2 сая төгрөг болж бууран, 1522.2 сая төгрөгийн зардал хэмнэсэн байна.

№	Ус ашиглагч	2016 он		2017 он		2018 он		2019 он		Нийт зөрүү
		Дүгнэлт	Тоолуур	Дүгнэлт	Тоолуур	Дүгнэлт	Тоолуур	Дүгнэлт	Тоолуур	
1	"Монгол Болгар гео" ХХК	167.4	14.3	86.3	9.5	167.7	16.0	154.8	-	536.42
2	"Спейшл майнз"ХХК / "Наран мандал энтейрпрайзес"/			25.2	11.6	42.8	18.1	26.2	18.5	46.06
3	"Вояжер минерал" ХХК					168.1	-	326.0	2.6	491.60
4	"Андын тэмүүлэл" ХХК	64.7	25.9	36.4	21.5	39.6	22.1	16.5	11.0	76.63
5	"Империял гоулд майнинг" ХХК			70.4	35.9	86.3	58.8	98.6	50.3	110.45
6	"Эл Ти Ди" ХХК							117.0	10.0	107.00
7	6. "Шижир аранжин" ХХК	42.7	-	46.3	20.0	53.0	11.2	43.2	-	154.08
	ДҮН	274.7	40.2	264.8	98.5	557.7	126.1	782.3	92.4	1,522.2

Тоолуур суурилуулсан зарим ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллага нь аудитад хамрагдсан зарим онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Тухайлбал:

- **“Вояжер минерал” ХХК** нь 2018 онд үйл ажиллагаа явуулаагүйг Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019.09.12-ний өдрийн 1/383 тоот албан бичгээр аймгийн Татварын хэлтэст албан тоотоор хүргүүлжээ. 2018 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.
- **“Шижир аранжин” ХХК** нь 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн тайлбар өгсөн нь БОАЖЯ-ны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын нөөцийн газарт явуулсан аймгийн БОАЖГ-ын 2016.12.13-ний өдрийн №304 тоот албан бичиг, Баянхонгор аймгийн МХГ-ын 2017.01.04-ний өдрийн 1/11 тоот албан бичгээр нотлогдож байна.

Аудитаар Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, аймгийн Татварын хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай хамтарч газар дээр нь тоолуурын

²⁰ ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах

заалтыг авч акт үйлдэн усны төлөөгүй байсан усны нийт 142.0 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллав.

Мөн “ИмпериаЛ гоулд майнинг” ХХК 2019.09.10-нд хийхэд 50,3 сая төгрөгийн ногдуулалт гарсан бөгөөд олборлогч оператор компани солигдож байгаа тул тус татварыг төлүүлэхээр акт тогтоов.

Мөн аудитын явцад зарим аж ахуйн нэгжүүдийн тоолуурын заалт баталгаажуулсан актыг тулгаж үзэхэд зөрүү гарч байв. Тухайлбал:

“Монгол болгар гео” ХХК 2017 онд тоолуураар тооцоо хийсэн бөгөөд 2017.05.20-2017.08.20 хүртэл тоолуурын заалтын акт үйлдсэн бөгөөд түүнээс хойш акт үйлдэж баталгаажуулаагүй, 2018 онд тоолуурыг 2018.09.15-нд баталгаажуулсан бөгөөд өмнөх саруудыг уурхайн зүгээс багцаагаар бодож 7521,7 мянган төгрөг төлсөн байв. Өмнөх онуудын тоолууртай байсан дундаж тооцоог хийхэд сард 3020,8 мянган төгрөг гарч байжээ. Иймд тоолуур ажиллаагүй үеийн тооцоог нөхөж хийхэд:

*2017 онд $1,5 * 3020,8 = 4531,2$ мянга 2018 онд $4 * 3020,8 = 12083,2$ мянга Нийт $16614,4 - 7521,7 = 9092,7$ мянган төгрөгийг нөхөн тооцож төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.*

Мөн 2019 онд Бөөнцагаан нуурын сав газарт тоолуур суурилуулах хүсэлт удаа дараа гарсан боловч хугацаа алдаж 2019 онд 07-р сарын 01-нд тоолуур суурилуулснаас төлбөр тооцоогүй байв. Аудитаар талбар дээр очиход тоолуур нь 67100 гэсэн заалттай байсан тул энэ нь тоолуур суурилуулснаас хойш 4885м3 буюу 4596,8 мянган төгрөг гарч 6000.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

Иймд тоолуур суурилуулснаас өмнөх хугацааны төлбөрийг жилийн эцсээр гэрээ дүгнэхдээ задгайгаар тооцож ногдуулалт хийх албан шаардлагыг Бөөнцагаан орог нуурын сав газарт хүргүүлэв.

“Шижир аранжин” ХХК нь 2019 онд тоолуурын заалтыг авахад 72848 буюу өмнөх оны эцсийн заалтаас 577 м3 –ээр нэмэгдсэн байгаа бөгөөд хэрэглээг бага гарсан шалтгааныг уурхайн дарга П.Энхтүвшин-с торуулахад “олборлолтын талбайд шүүрлийн ус гарч ирсэн бөгөөд гүний ус хэрэглэхгүй шүүрлийн ус ашиглаж байгаа” гэсэн тайлбарыг өглөө.

Иймд шүүрлийн усыг ашиглах тарифаар бодон ногдуулалт хийж төлбөрийг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд хүргүүлэв.

Харин усны тоолуур суурилуулаагүй ус ашиглагч нарын усны тайланг авч усны төлбөрийн тооцоог хийж байгаа боловч гэрээ дүгнээгүй усны төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.

№	Ус ашиглагч	2016 он		2017 он		2018 он		2019 он		Нийт зөрүү
		Дүгнэлт	Төлсөн	Дүгнэлт	Төлсөн	Дүгнэлт	Төлсөн	Дүгнэлт	Төлсөн	
1	"Ай Эн Ди" ХХК	135.4	32.4	162.9	44.3	-	-	168.4	-	390.0
2	"Эрдэнэ цагаач" ХХК					30.0	1.0	36.0	3.0	62.0
3	"Одод гоулд" ХХК					52.4	9.2	64.3	19.3	88.2
4	"Одод гоулд" ХХК							56.9	-	56.9
5	"Мөнхийн Номхон далай" ХХК							91.6	-	91.6
6	"Шинэсансар" ХХК	83.8	12.0							71.8
7	"Ти Энд Ти Юникс" ХХК			46.4	13.1					33.3
8	"Тинаха" ХХК	32.5	6.7							25.8
9	"Жамп Алт" ХХК	39	26.7	24.6						36.9
10	"Нинжмөрөн" ХХК	131.8	4.2	172.9	4.5					296.0
11	"Ногоон даваа" ХХК					90.70				90.7
12	"Жамп" ХХК					107.8				107.8
13	"Аурум металс" ХХК					61.6	3.0			58.6
	Дүн	422.5	82.0	406.8	61.9	342.5	13.2	417.2	22.3	1,409.6

Аудитад хамрагдсан онуудад нэр бүхий 8 компани нь үйл ажиллагаа явуулж байсан боловч 2019 онд дүгнэлт гаргуулж үйл ажиллагаа явуулаагүй байгаа бөгөөд эдгээр компаниудын усны төлбөр 720,9 сая, 2019 онд үйл ажиллагаа явуулж буй 3 компанийн 293,8 сая төгрөг барагдуулаагүй байгаа тул нийт 1014,7 сая төгрөгийн усны төлбөрийн тооцоог хуулийн байгууллагад шилжүүлж барагдуулах албан шаардлагыг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, аймгийн Татварын хэлтэс, МХГ, БОАЖГ -уудад хүргүүлэв.

2019 онд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуйн нэгжийн усны тайланг бүрэн авч усны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанд зөвлөмжөөр хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Жи Энд Юу Голд ХХК нь Хяргас нуур-завхан голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг 2014 оноос хойш байгуулан ажиллаж байгаа ба ус ашигласны төлбөрийг ногдуулалтыг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас хийж ногдуулалтын дагуу усны төлбөрт 67,9 сая төгрөгийн төлсөн байна.

Харин Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 оны 5 дугаар сарын 4 өдөр үйл ажиллагааг түр зогсоож, аймгийн Прокурорын газрын тогтоол гарч 2018 оны 5

дугаар сарын 7-ний өдөр үйл ажиллагааг зогсоосны дагуу үйл ажиллагаа бүрэн явуулаагүй гэсэн шалтгаанаар 2018 оны усны төлбөрийн орлогыг төлөөгүй байна.

Гэвч аймгийн Прокурорын газрын 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор 2018 оны уулын ажлын төлөвлөгөөнөөс хэтрүүлж явуулсан үйл ажиллагааг зогсоож төлөвлөгөөнд тусгагдсан хэсэгт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгожээ.

Тус компанийн ус ашиглалтын тайланг шалгахад уул уурхайд 43940 м3 ус хэрэглэсэн тайлан гарсан боловч нөхөн сэлбэлтийг хур тунадас болон шүүрлийн усыг дахин ашигласан гэсэн тайлан гаргасан байгаа ба аудитаар тус компани 2018 онд баяжуулсан элсний хэмжээ, өмнөх онуудын усны төлбөрийн ногдуулалттай харьцуулан тооцож үзэхэд 14,9 сая төгрөгийг дутуу төлсөн тул төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

✚ Төвлөрсөн усан хангамжаар ус түгээж буй ус ашиглагч

“Чандмань Баянхонгор” ХК-ийн гаргуулсан ус ашиглах дүгнэлтэд усны төлбөрийн хэмжээг тусгаагүй, гэрээ байгуулаагүй ногдуулалтыг тооцоогүй байна.

Аудитаар тус компанийн 2018 оны ус түгээсэн бүртгэлийг түүвэрлэж усны гүйцэтгэлийн тайлантай тулгахад нийт олборлосон ус нь 45582 м3 ус зөрүүтэй гарсан бөгөөд энэ талаар тайлбар тодруулга авахад “ усны насосын хий шахалт, буцааж алдалт зэргийг тооцож олборлосон усны 80%-иар гүйцэтгэл гаргадаг” гэсэн тайлбарыг ирүүлэв. Усны бодит хэрэглээг гаргаж хяналтын тоолуур суурилуулж усны хэмжээг бодитоор гаргаж байх зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор”ХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн байна.

Усны төлбөрийг аргачлалаар тооцоход:

№	Ангилал	Усны төлбөр дүгнэлтээр					Төлөх усны төлбөр гүйцэтгэлээр				
		2016	2017	2018	2019	Нийт	2016	2017	2018	2019	Нийт
1	Айл өрх/унд, ахуй/	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Төсөвт байгууллага, албан газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3	Хүнсний үйлдвэрлэл	68.8	59.7	59.7	59.7	248.0	69.8	69.8	69.8	82.7	292.0
4	Халаалтын зуух /эрчим хүч/	684.8	1310.7	1310.7	1537.6	4843.9	975.4	1323.6	1850.4	1992.8	6142.2
5	Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл, үйлчилгээ	3483.3	1480.4	1878.8	1822.4	8664.9	2494.0	2405.5	2451.6	2451.6	9802.7
6	Дотоод хэрэгцээ	0.0	423.2	423.2	423.2	1269.6	698.0	34.9	34.9	113.4	881.3
Тайлант оны дүн		4236.9	3274.0	3672.4	3842.9	15026.3	4237.3	3833.7	4406.7	4640.5	17118.2
Төлсөн		0.0	0.0	0.0	0.0	0.0	2000.0	3189.9	2000.0	0.0	7189.9
Дутуу		4236.9	3274.0	3672.4	3842.9	15026.3	2237.3	643.8	2406.7	4640.5	9928.2

Айл өрхийн унд ахуй зориулалтаар хэрэглэсэн усыг төлбөрөөс чөлөөлж, бусад ус ашиглагчийн усны төлбөрийг усны тухай хуулийн дагуу гэрээ байгуулж 2019 оноос эхлэн төсөвт бүрэн төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг Чандмань Баянхонгор ХК-д хүргүүлж, дутуу төвлөрүүлсэн 9928,2 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Уул уурхай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ус ашиглагч

Байгаль орчны газраас хайгуулын чиглэлээр гаргасан ус ашиглах дүгнэлт болон сумын Засаг дарга нартай байгуулсан ус ашиглагчийн гэрээний дагуу усны төлбөрийн ногдуулалт болон гүйцэтгэлийг тооцон шалгахад 2016-2018 онуудад 83 ус ашиглагч усны төлбөрт 81,6 сая төгрөгийн төлбөр төлөхөөс 44,3 сая төгрөгийн төлбөрийг төлж 37,3 сая төгрөгийг төвлөрүүлээгүй тул төлбөрийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн БОАЖГ, аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

Рашаан сувиллын зориулалтаар ус, рашаан ашиглагч

“Амар амгалан сувилал”ХХК-ийн 2019 оны үйлчлүүлэгч хүлээн авсан бүртгэлийг шалгахад 1034 хүний 5136 хүн хоног амарсан байна. Усны рашаан ашигласны төлбөрийг аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу тооцож үзэхэд 1844,5 мянган төгрөг гарсан бөгөөд төлбөрийг төсөвт нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

“Баян-Ундарга зэндмэнь”ХХК-ийн эмчлүүлэгчийн бүртгэл, кассын баримтыг түүвэрлэн шалгахад амрагчдын тоог дутуу мэдээлснээс 1582,7 мянган төгрөгийн ногдуулалтыг дутуу хийж усны төлбөрийг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

“Шаргалжуут рашаан сувилал”ХХК-ийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан мэдээнд тусгасан хүний тоотой тулган үзэхэд гүйцэтгэлээс илүү рашаан ашиглаж тайлан мэдээг үнэн бодитой гаргаж өгөөгүйн улмаас 15,4 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

Дээрх байдлаас харахад Шаргалжуут тосгон, Бага Шаргалжуут, Галуут сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Өргөөт, Өхэг зэрэг бусад рашаан сувиллыг түшиглэн үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газруудад өдрөөр үйлчлүүлж буй амрагчдын бүртгэл тооцоо байхгүй, ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг татварт төвлөрүүлээгүй байна.

Тухайлбал Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрших “Аварга тосон” рашаан сувилалд сумын ИТХ-аас тогтоол гаргаж хог хаягдал, рашаан ус хөрс

элэгдүүлсэн зэрэг хураамжийг нэгтгэн 1 авто тээврийн хэрэгслээс 5000 төгрөг, иргэнээс 500 төгрөгийг тооцон авч байгаа жишээ байна.

Дээрх байдлаас үзэхэд хяналтыг бий болгож ус рашаан, хог хаягдлын хураамжаар орон нутгийн орлого нэмэгдэх бололцоотой гэж үзэж байгаа тул асуудлыг судалж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т өгөв.

Төвлөрсөн уурын зуух

Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас 2016 онд аймгийн төвд дулаан үйлдвэрлэгч 7 уурын зуухны ус ашиглах дүгнэлт гаргасан боловч тухайн аж ахуй нэгж байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулаагүй байв.

2017-2019 онуудад ус ашиглах дүгнэлт гаргаагүй байсан тул Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь ус төлбөрийн ногдуулалтыг гаргаж аймгийн Татварын хэлтэст хүргүүлсний дагуу усны төлбөрийн ногдуулалтыг хийсэн байна.

№	Аж ахуй нэгжийн нэр	2016		2017		2018		Нийт дүн		Зөрүү
		Дүгнэлт	төлсөн	Сав газрын ногдолт	төлсөн	Сав газрын ногдолт	төлсөн	Нийт ногдолт	төлсөн	
1	"Эх бүрдэн" ХХК	1,390.2	1,032.0	1,486.4	-	1,487.3	-	4,363.9	1,032.0	3,331.91
2	"RMB" ХХК	1,985.6	1,337.6	1,911.1	1,337.0	2,124.2	1,337.0	6,020.8	4,011.6	2,009.28
3	Марал гүн ХХК	-	-	1,786.7	-	1,786.4	-	3,573.1	-	3,573.13
4	"Баялаг Дулаан" ХХК	1,350.0	1,003.4	1,443.3	2,739.7	1,444.1	2,739.7	4,237.5	6,482.9	
5	Рашаант Хайрхан ХХК	1,428.2	1,335.9	1,400.1	1,528.1	1,528.1	1,528.1	4,356.3	4,392.1	
6	Хөвших Од ХХК	535.7	689.9	478.9	728.0	574.6	728.0	1,589.2	2,145.9	
7	Зүүн шанд ХХК	954.1	-	1,275.0	1,020.5	1,020.6	1,020.5	3,249.8	2,041.0	1,208.77
8	4-р 10 жил зуух	-	-	212.0	-	-	-	212.0	-	212.03
Дүн		7,643.9	5,398.8	9,993.6	7,353.3	9,965.2	7,353.3	27,602.7	20,105.4	10,335.1

Дээрх хүснэгтээс харахад аймгийн төвийн 4 уурын зуух 10,3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ талаар Бөөнцагаан Орог нуурын сав газраас тодруулахад "Чандмань-Баянхонгор" ХК-ний нэгдсэн шугамд холбогдсон учраас гүний худаг ашиглахгүй байгаа гэсэн шалтгаанаар дүгнэлт гаргуулаагүй, усны төлбөр дутуу төвлөрүүлсэн гэсэн тайлбар өгөв.

Дулаанаар хангагч байгууллагуудын “Чандмань-Баянхонгор” ХК-д төлсөн төлбөрийг хүснэгтээр харуулав.

Аудитын явцад “Чандмань-Баянхонгор” ХК-аас дээрх дулаанаар хангагч байгууллагуудыг гэрээг ирүүлэхийг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй.

Цаашид Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ус ашиглагч

	2016 он	2017 он	2018 он
ААНБ-н нэр			
"Эх бүрдэн" ХХК	901.8	4,575.3	5,945.9
"RMB" ХХК	7,479.9	4,673.5	6,345.5
Марал гүн ХХК	10,275.8	4,629.5	6,347.2
"Баялаг Дулаан" ХХК	1,200.0	3,641.9	3,769.1
Рашаант Хайрхан ХХК	1,624.7	4,629.5	6,347.2
Хөвших Од ХХК	-	-	-
Зүүн шанд ХХК	1,719.8	5,419.7	6,507.7
4-р 10 жил зуух	-	2,738.4	4,071.5
Гал хонгор ХХК	7,741.4	6,120.7	6,120.7
Дүн	30,943.5	36,428.6	45,454.7

аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн тоолууржуулж, тус хуулийн 29.1-т заасны дагуу гэрээ байгуулж ус ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн татварт бүрэн төвлөрүүлэх зөвлөмжийг “Чандмань Баянхонгор” ХК-д хүргүүлэв.

Аудитаар нийт 1191,9 сая төгрөгийн зөрчил илэрч 139,9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 1052.0 сая төгрөгийн албан шаардлага өгч хуулиар тогтоосон үүрэг биелүүлээгүй буюу хариуцлага алдсан холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг МХГ-т хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн бодит бус төлөвлөх байдал давтагдан гарсаар байна.
2. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан хуульд заасны дагуу 35 хувиар тооцон аймгийн БОАЖГ-ын төсөвт оруулан баталж байна.
3. Ус, рашаан ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын хяналт сул, мэдээлэл нээлттэй бус, ажлын уялдаа холбоо муугаас ус, рашаан ашиглагчтай гэрээ хийгээгүй, усны тайланг бүрэн гаргаагүй, зөвшөөрөлгүй ус ашигласан, төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэрэг хууль зөрчдөг байдал нийтлэг байна.
4. Татварын байгууллага нь ус, рашаан ашигласны төлбөрийн тайланг баталгаажуулахдаа ногдуулах суурь үзүүлэлтэд хяналт тавилгүй, төлбөр төлсөн дүнгээр нь ногдуулалт хийсэн тайланг хүлээн авсан зөрчил дахин давтагдаж гарсаар байна.
5. Бөөнцагаан Орог нуурын сав газар нь дүгнэлт гаргахдаа өөрийн чиг үүрэгт хамаарахгүй ус ашиглагчид дүгнэлт гаргасан бөгөөд тус дүгнэлт нь алдаатай гарчээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа танаа:

1. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлоготой холбоотой зөвшөөрөл, хийсэн гэрээ, төлбөрийн тайлан мэдээг гаргасан дүгнэлттэй харьцуулан үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлан, төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.

2. Рашаан сувилал түшиглэн үйл ажиллагаа явуулж буй газруудад Ус рашаан ашигласны төлбөр, хог хаягдлын хураамжийн орлого хураах, орон нутгийн орлого нэмэгдэх асуудлыг судалж хэрэгжүүлэх асуудлыг судалж холбогдох сумдын Засаг дарга нарт арга зүйгээр хангаж ажиллах.

Хоёр. Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанд:

1. Ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн хамруулан ус ашиглах дүгнэлтийг аргачлалын дагуу үнэн зөв гаргаж, гэрээ байгуулж ажиллах.

2. Ус ашиглагч нарыг бүрэн Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу бүрэн тоолууржуулж, тэдгээрт байнгын хяналт тавьж, төсөвт төвлөрөх усны төлбөрийг төвлөрүүлж ажиллах.

3. Усны тухай хуулийн 17.1.8-д заасны дагуу сав газрын хэмжээнд ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавих үүргээ хэрэгжүүлж, ус ашиглагчидтай хийсэн гэрээг дүгнэж ажиллах.

4. Усны тухай хуульд заасны дагуу бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах үүргээ биелүүлж гэрээ байгуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.

Гурав. Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт:

1. Ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн хамруулан ус ашиглах дүгнэлтийг аргачлалын дагуу үнэн зөв гаргаж, гэрээ байгуулж ажиллах.

2. Сумдын төвлөрсөн уурын зуухыг тоолууржуулж гүйцэтгэлээр нь усны төлбөрийг тооцож төсөвт төвлөрүүлж байх.

3. Усны мэдээллийн санг бүрдүүлж, хуульд заасны дагуу сав газрын захиргааг мэдээллээр хангах үүргээ хэрэгжүүлж, гаргасан дүгнэлтийн талаарх мэдээллийг аймгийн Татварын хэлтэст хүргүүлж байх.

Дөрөв. Аймгийн Татварын хэлтэст

1. Ус, рашаан ашигласны төлбөрийн тайланг хүлээн авч баталгаажуулахдаа сав газрын захиргаа, аймгийн БОАЖГ-аас гэрээ дүгнэсэн материалыг авч ногдуулалтад хяналт тавьж, төсөвт төвлөрөх усны төлбөрийг бүрэн төвлөрүүлж ажиллах.

2. Ус, рашаан ашигласны төлбөрийн тайланг ус ашиглагч байгууллагуудаар бүрэн, үнэн зөв гаргуулж байх.

Тав. “Чандмань-Баянхонгор” Хувьцаат компанид:

1. Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн тоолууржуулж, тус хуулийн 29.1-т заасны дагуу гэрээ байгуулж ус ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн татварт бүрэн төвлөрүүлэх зөвлөмжийг “Чандмань Баянхонгор”ХК-д хүргүүлэв.

Зургаа. Сумдын Засаг дарга нарт

1. Өөрийн нутаг дэвсгэрт харьяалалтай рашаан ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудын ус ашиглах дүгнэлтийг үндэслэж гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

2. Рашаан сувилалд хамрагдаж буй амрагчдын өдрөөр үйлчлүүлэгчдэд хяналт тавьж рашаан ашигласны төлбөрийг төвлөрүүлж, орон нутгийн орлого нэмэгдэх бололцоог бий болгох.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.